# НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
# ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 15 өдөр Дугаар А/122 Улаанбаатар хот

Цэргийн албыг биеэр дүйцүүлэх албанд иргэдийг элсүүлэх, хугацаа дууссан алба хаагч нарыг албанаас халах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.2, 30.3, 30.7, 30,9 Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол, 2021 оны 220 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2022 оны 35 дугаар тогтоол, нийслэл Засаг даргын 2022 оны А/771 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь.

1 2021 оны хоёрдугаар ээлжийн Цэрэг татлагын товчооны хурлын шийдвэр, цэргийн дүйцүүлэх албыг биеэр хаах хүсэлт гаргасан иргэдийн асуудлыг шийдвэрлэх, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны шийдвэр, нийслэлийн Засаг даргын захирамжаар ирүүлсэн тоон даалгаварт багтаан тус дүүргийн харьяат 4 иргэнийг элсүүлэн үүрэг гүйцэтгүүлэх, 2020 онд элсэж алба хаах хугацаа дууссан иргэдтэй ажлын хоногийн тооцоог хийж халах, хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаахтай холбоотой тогтоол, дүрэм, журмыг зөрчсөн иргэдтэй гэрээг цуцлан халж төлбөр тооцоог дуусгаж халах ажлыг зохион байгуулсугай.

2 Алба хаахаар элссэн иргэдийг 2022 оны 06 дугаар сарын 17-ноос 30 ны өдрүүдэд нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдах цэргийн дүйцүүлэх албаны бэлтгэл шатны сургалтад бүрэн хамруулахыг Цэргийн штаб (хурандаа Б.Батмөнх)-т үүрэг болгосугай.

3 Цэргийн дүйцүүлэх албанд элсэн 2022-2024 онд алба хаах иргэдийн нэрийг нэгдүгээр, хугацаа дуусаж халагдах, гэрээ цуцлан албанаас халах иргэдийн нэрийг хоёрдугаар, Цэргийн дүйцүүлэх алба хаах иргэдийн албаны хувцас хэрэглэлийн зардлын тооцоог 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4 Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хаах иргэдийн үүрэг гүйцэтгэх үеийн хувцас хэрэглэлийн зардал 2867900 (хоёр сая найман зуун жаран долоон мянга есөн зуу) төгрөгийг дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5 Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц.)-т үйл ажиллагааг зохион байгуулж дууссанаас хойш 5 хоногийн дотор танилцуулах, зарцуулсан санхүүгийн тайланг ирүүлэхийг Цэргийн штаб (хурандаа Б.Батмөнх)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА С.Эрдэнэбаяр С.ЭРДЭНЭБАЯР

AJIL\2022 он ажил\захирамж

1123200500

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2022 оны 06 сарын 15-ны өдрийн А/122 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

2022-2024 онд цэргийн дүйцүүлэх албыг
биеэр хаах иргэдийн нэрийн жагсаалт

| д/д | Овог нэр | Регистр | Гэрийн хаяг | Холбоо барих утасны дугаар |
|---|---|---|---|---|
| 1 | Алтанхүү Алтантулга | НЦ00322518 | Багахангай дүүрэг 1-р хороо 4-45 тоот | 89601225<br>88081368 |
| 2 | Батнасан Ганбилэг | УХ00212657 | Багхангай дүүрэг 1р хороо 4 байр 20 тоот | 99080568<br>99110568 |
| 3 | Дашзэвэг Мөнх-Эрдэнэ | НВ02210319 | Багахангай дүүрэг 1-р хороо 3 байр 72 тоот | 94413772<br>99133178 |
| 4 | Наранхүү Цолмонбаатар | Н302311710 | Багахангай дүүрэг 1-р хороо 2 байр 105 тоот | 88516558<br>99796558 |

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2022 оны..06 сарын..15-ны өдрийн A/92 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

2020-2022 онд цэргийн дүйцүүлэх албыг биеэр хааж
хугацаа дуусган халагдах, гэрээ цуцалж албанаас
халах иргэдийн нэрийн жагсаалт

| д/д | Овог нэр | Регистр | Гэрийн хаяг | Элссэн он | Үүрэг гүйцэтгэсэн хоног |
|---|---|---|---|---|---|
| 1 | Төмөрбаатар Баярбаатар | НЦ00310311 | Багахангай дүүрэг 2-р хороо Бор-Үзүүр 3-7 тоот | 2020 | 191 хоног |
| 2 | Хишигдолгор Бямбатулга | НЦ98112113 | Багахангай дүүрэг 1-р хороо Хангамж 1-15 тоот | 2020 | 186 хоног |
| 3 | Гантулга Өлзийбат | НЦ00321110 | Багахангай дүүрэг 2-р хороо Бор-Үзүүр 2-4 тоот | 2020 | 173 хоног |
| 4 | Содовжамц Хосбаяр | НЦ97102412 | Багахангай дүүрэг 1-р хороо 4 дүгээр байр 4-21 тоот | 2020 | 152 хоног |
| 5 | Мөнхбат Ганбат | НЦ00320813 | Багахангай дүүрэг 2-р хороо Цайдам 1-3 тоот | 2020 | 151 хоног |
| 6 | Цогбадрах Алтай | УП98053116 | Багахангай дүүрэг 2-р хороо Бор-Үзүүр 4-2 тоот | 2020 | 148 хоног |
| 7 | Нямхишиг Өлзийтогтох | НЦ00260816 | Багахангай дүүрэг 2-р хороо Өртөөний хэсэг 15 тоот | 2020 | 36 хоног Гэрээ цуцлах |
| 8 | Загдрагчаа Аранжин | ОЮ98080212 | Багахангай дүүрэг 1-р хороо Үнэгтэй хэсэг 4-1 тоот | 2021 | 32 хоног Гэрээ цуцлах |

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2022 оны 06 сарын 15-ны өдрийн А/122 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

2022-2024 онд цэргийн дүйцүүлэх албыг биеэр хаах
иргэдийн хувцас, хэрэглэлийн зардлын тооцоо

| д/д | Хувцас хэрэглэлийн нэршил | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|
| 1 | Малгай /зуны саравчтай/ | 4 ширхэг | 15.000 | 60.000 |
| 2 | Малгай /өвлийн ноосон/ | 4 ширхэг | 15.000 | 60.000 |
| 3 | Китель өмд /зуны/ | 4 хос | 130.000 | 520.000 |
| 4 | Хүрэм өмд /өвлийн/ | 4 хос | 180.000 | 720.000 |
| 5 | Нэр /алба хаагчийн/ | 8 ширхэг | 3.500 | 28.000 |
| 6 | Албаны нэр | 8 ширхэг | 3.500 | 28.000 |
| 7 | Ханцуйн тэмдэг /дүүргийн лого/ | 8 ширхэг | 6.000 | 54.000 |
| 8 | Ханцуйн тэмдэг /Цэргийн штаб лого/ | 8 ширхэг | 6.000 | 54.000 |
| 9 | Гутал /хагас түрийтэй/ | 4 ширхэг | 120.000 | 480.000 |
| 10 | Унааны зардал | 2 удаа явах | 1860 x 45л | 83.700 |
| 11 | 4 алба хаагчийн 14 хоногийн зардал | 4 хүн 14 хоног | 15000 | 840.000 |
| Нийт | | | | 2.867.700 |